

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭТГЭЛ

МОНГОЛ ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН
ШИНЭТГЭЛИЙГ БНХАУ, ЗҮҮН
ЕВРОПЫН ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛСАН НЬ

*Жан Зен Ву**
*Ку Сяо Чжун**

1. Эдийн засгийн шилжилт бол эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэх үндэс мөн. Эдийн засгийн гадаад харилцааны (олон улсын Эдийн засагт нэгдэх) хөгжилт нь эдийн засгийн дотоод тогтолцооны шилжилтийн явцыг дэмждэг. Монгол нь хуучин ЗХУ-ын дараа ордог хоёр дахь коммунист орон байлаа. Өнгөрсөн 60 гаруй жилийн хугацаанд улс төр, эдийн засаг нь Зөвлөлтийн загварыг үндсэндээ баримталсан тогтолцоотой байв. Түүний эдийн засгийн гадаад харилцаа ЭЗХТЗ-ийн нөлөөлөлд ихээхэн хэмжээгээр орсон байв. 1990 оны улс төрийн өөрчлөлт ЭЗХТЗ-ийг задлаж, түүний эдийн засгийг унагасан явдал нь Монголыг эдийн засгийн өргөн хүрээтэй өөрчлөлтийн замд түлхэн оруулсан юм. Үүний зэрэгцээгээр түүний эдийн засгийн гадаад харилцаа аажмаар өргөжиж байна. Өнгөрсөн таван жилийн хугацаанд нийт 400 сая гаруй хэмжээний америк долларын зээл, тусламж авч ашиглажээ. Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа өсч Япон, АНУ-тай эдийн засгийн талаар хамтран ажилласнаас зохих үр дүнд хүрчээ. Европын холбоотой эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжсөн шинэ нөхцөл бас аажмаар бүрэлдэн эхэлж байна. 1994 оны сүүлчээр, Монгол 30 гаруй орон бүстэй холбоо тогтоож, тэдний зургаатай эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны гэрээнд, 11 оронтой хөрөнгө оруулалт хамгаалах хэлэлцээрт тус тус гарын үсэг зурж, давхар татвар авахаас зайлсхийхтэй холбогдсон хэлэлцээрийг хэд хэдэн оронтой байгуулжээ. Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхийн зэрэгцээгээр санхүү, гадаад солилцоо, Гадаад хөрөнгө оруулалтын тогтолцоо, эдийн засгийн гадаад харилцааны тогтолцоог бүхэлд нь өөрчлөх шаардлага өсөж байна. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хурдасгах шаардлага ч бас өсөж байна. Улс төр, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт Монголыг нээлттэй болгох үндсэн нөхцлийг бий болгосон нь илэрхий байна. Гадагшаа нээлттэй байдал өсөж байгаа нь эргээд тогтолцооны шилжилтийг дэмжиж, энэ нь коммунист байсан бүх орнуудын хөгжилд нэгэн нийтлэг шинж болж байна.

2. Монгол улс хувьчлал хийх, зах зээлд шилжихэд асар их дэвшил гаргажээ. Гэвч эдийн засгийн шилжилт олон шинэ асуудалтай тулгарсаар байна. 1991 оноос хойш хувьчлах, үнэ чөлөөлөх, эдийн засгийг нээлттэй болгох зэрэг арга хэмжээгээр дамжуулан зах зээлийн ндийн засагт чиглэсэн өөрийн шилжилтийг хурдасгаж, гол нь хувийн хэвшил бүхий эдийн засгийн шинэ механизмын урьдчилсан баазыг буй болгожээ.

Гэвч эдийн засгийн зохих өсөлт болон эдийн засгийн гадаад хөгжлийг дэмжиж чадах эдийн засгийн тогтолцоог тогтооход янз

*Хятадын Нийгмийн ухааны Академийн Дорнод Европ Орос. Төв Азийн судлалын хүрээлэнгийн захирал, профессор

*Хятадын нийгмийн ухааны Академийн Дорнод Европ, Орос, Төв Азийн судлалын хэлтсийн орлогч: эрхлэгч, дэд профессор

бүрийн асуудалтай тулгарсаар байна. Цаашид тулгарч байгаа дараахь асуудлууд байна. Бага хувьчлал амжилттай байгаа боловч нийт хувьчлал маш удаан явцтай байна. Өмчийн тогтолцоо боловсронгуй бус байгаагаас гадна компанийн хууль, аж ахуй хоорондын гэрээний хууль, үнэт цаасны хууль зэрэг багц хууль дутагдалтай байсаар байна. Хувьчлалын хөтөлбөр улсын активыг хувийн өмчид хууль ёсоор шилжүүлэхэд үр дүнд хүрсэн боловч өмчийн бүтцийн хэт тархай байдлаас аж ахуйн бие даасан хуулийн этгээдийн хувьд эрчимтэй удирдлага хэрэгжиж чадахгүй байна. Ийм учраас үйлдвэрүүдийн удирдлагад өөрчлөлт гарахгүй байна. Үйлдвэрийн хувьцааг захад чөлөөтэй худалдахад тэр нь хувийн актив шиг хялбар гүйж чадах бөгөөд үйлдвэрийн үр ашиг дээшилж, жинхэнэ хувьчлал ирнэ. Хувьчлал бол зорилго биш, эдийн засгийн үр дүнг сайжруулах хэрэгсэл юм. Санхүү, банкны салбарын өөрчлөлт эдийн засаг, гадаад харилцааны хөгжлийн шаардлагыг хангаж чадахгүй байна. Олон тооны худалдаа, хувийн банкууд өөрчлөлтийн эхний үед байгуулагджээ. Эрчимтэй удирдлага дутагдаж, ёс суртахууны хямрал болсон зэргээс ихэнх банк ихээхэн эргэж төлөгдөхгүй зээл зээлдүүлж санхүүгийн ноцтой хүнд байдалд орсон юм. Төв банк төгрөгийг хөрвөх мөнгө болгож, санхүүгийн тогтвортой хөтөлбөрийг хэрэгжүүлж баяна. Гэвч тогтвортой байдалд сөргөөр нөлөө үзүүлсэн юм. Гадаад хөрөнгө оруулалтын хууль, эдийн засгийн тусгай бүсийн хууль, газар ашиглалтын болон түрээслэлийн хууль боловруулагдсан боловч эдгээр хууль гадаад хөрөнгө оруулалтыг татах, үйлдвэрлэлийг дэмжихэд эрчимтэй үүрэг гүйцэтгэж чадахгүй байна.

Төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үеийн хүнд суртал, тэгштгэх ёс сүйрсэн боловч, зах зээлийн хуваарилалтын шинэ тогтолцоо бүрэлдэж, боловсронгуй болоогүй байна. Авилгал, эдийн засгийн гэмт хэрэг, хоёр тийш туйлшрах явдал нэн ноцтой байна. Хятад болон хуучин ЭЗХТЗ-ийн орнуудтай харьцуулахад Монголд тогтолцооны өөрчлөлт гэх мэтийг хамарч байна. Шилжилтийн загварын нэр томъёог үндэслэн яривал Монгол “түргэн эмчилгээ” буюу “муужруулах” гэхээсээ аажим хандах хандлагыг хэрэглэж байна.

3. Монголын гадаад эдийн засгийн харилцаа ЭЗХТЗ-ийн хямралаас өөрөө бие даан гарах шаардлагаас эхэлсэн юм. Олон зүйл өөрчлөгдөв. Гэвч эдийн засгийн гадаад харилцааны хөгжилт хүндхэн сорилттой тулгарсаар байна.

Өнгөрсөн таван жил гаруй хугацаанд Монгол гадаадын хөрөнгө оруулалтыг нэвтрүүлж, эдийн засгийн хямралыг давах болон хөгжлийг дэмжих чухал арга хэмжээ болох гадаад тусламжинд чармайлт тавин эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлж байна.

Энэ зорилгоор гадаад худалдааны хүнд сурталт тогтолцоог өөрчилж, уян хатан гадаад эдийн засгийн журам, хуулиудыг боловсруулан өөрийн оронд эдийн засгийн хөгжлийн 7 бүсийг тогтоожээ. 1994 онд

Монголын гадаад худалдааны хэмжээ 480 сая ам.доллар, өнгөрсөн 50 жилийн хугацаанд актив анх удаа 110 сая ам.долларт хүрчээ. Зэс, ноолуур, ноолууран бүтээгдэхүүн олон улсын зах зээлд гүйлгээ сайтай байна. Гадаадын хөрөнгө оруулалт бас амжилтанд хүрчээ. 1993 оны 10-р сард Дарханы төмөр, болдын үйлдвэр баригдаж жилд 100000 тонн боловсруулах хүчин чадалтайгаар ашиглалтад орсон байна. Энэ үйлдвэрийг Монгол, Япон, Оросын талууд хамтран санхүүжүүлжээ. 1994 оны 12 дугаар сарын дундуур Зүүнбаяны нефтийн цооног, талбайг Монгол, АНУ хамтран судалж, өрөмдсөн нь анхны үр дүн байлаа.

Ийм ололт байвч Монголын эдийн засгийн гадаад харилцааг хөгжихөд сүрхий бэрхшээл байсаар байна. Ерөнхийд нь хэлэхэд гадаад худалдаа, гадаад хөрөнгө оруулалт харьцангуй бага байгаа бөгөөд түүний дотоод болон олон улсын зах зээлийн хөгжил зохих шаардлагаас их хол байна. Олон улсын болон бүсийн хамтын ажиллагааны бололцоог бүрэн ашиглах шаардлага байна. Энэ бүхэнд хувь нэмэр оруулж байгаа хүчин зүйлүүд гэвэл тогтолцоо, эдийн засгийн бүтэц, соёлын уламжлалтай холбогдсон зүйлүүд орж байна. Одоо дараахь зүйлүүдийг хийх хэрэгтэй байна.

Журам, хууль хүчтэй биш байна.

Макро эдийн засгийн тогтвортой байдал дутагдаж, хөрөнгө оруулалтад нөлөөлж байгаа мөнгөний ханш уналт өндөр байна. Тогтвортой мөнгө, гадаад солилцооны ханш үндсэн өөрчлөлтийн арга хэмжээнээс хамаарч байна. Банк, даатгал ялангуяа гадаад бизнес, эрчимтэй хөгжлийг шаардаж байна. Тээвэр, теле харилцаа холбоо хоцорч, дотоодын эдийн засгийн хөгжилд явцуу байдлыг бий болгон гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон үйлдвэрлэлийн хамтарсан Хазар байгуулахад түлш, эрчим хүчний систем ноцтой саад учруулж байна.

Хятад болон хуучин ЭЗХТЗ орнуудтай харьцуулахад Монголд адил төстэй зүйлүүд байхын зэрэгцээгээр нээлттэй бодлого явуулах болон эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхэд өөрийн өвөрмөц онцлогуудтай юм. Төв, зүүн европын орнууд Европын хамтын нөхөрлөл, Европын хорших хөтөлбөртэй нэгдэх замаар өөрийн нээлттэй бодлогын стратегийг хэрэгжүүлэхийг оролдож байна. Хятадын хувьд хоёр талын эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэх болон бүсийн ба дэлхий нийтийн худалдааны тогтолцоонд нэгдэх үндсэн дээр олон улсын эдийн засагтай аль болохоор хурдан хоршихыг голчлон эрэлхийлж байна. Өнгөрсөн 60 жилийн хугацаанд Монгол улс хуучин ЗХУ болон ЭЗХТЗ-ийн орнуудтай харьцангуй тогтмол харилцаж гадна бусад орнуудтай маш бага холбоо тогтоон “нэг талт руу хэлбийсэн” бодлого барьж байлаа. Өнөөдөр үндсэн өөрчлөлт гчээ. Гэвч уламжлал, туршлага дутагдалтай, газарзүйн байршил, эдийн засгийн хөгжлийн нөхцлүүдээс болж Монгол гадаад эдийн засгийн стратегийг оролцуулан өөрийн гадаад бодлогыг судлах шатандаа байгаа бөгөөд орчин үеийн ертөнцөд өөрийн шинэ байр суурийг хайж байна. 1994 оноос Монгол өөрийн ирээдүйн гадаад эдийн засгийн стратегийн бодлогын үндсийг хангаж байгаа “Монголын гадаад бодлогын үзэл баримтлал” гэсэн хөтөлбөр баримт бичгийг анх удаа хэрэглэжээ. Уг баримт бичиг “гадаад бодлогод Орос, БНХАУ-тай нөхөрсөг харилцааг хөгжүүлэх нь Монголын гадаад

бодлогын гол зорилго мөн" гэж дэмжиж байна. Эдийн засаг, худалдааг хөгжүүлэхэд юуны өмнө Ази болон Ази-Номхон далайн бүстэй эдийн засгийн хамтын ажиллагаанд анхаарлаа давуу хандуулж байна. Азийн орнуудын дунд Хятад, Японтой харилцааг хөгжүүлэхэд хүч тавьж байна. Үүний хамт бас АНУ, Япон, Европын холбоо, өрнөдийн хөгжингүй бусад орнуудтай эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэхийг баримт бичигт заажээ. Олон улсын мөнгөний фонд (IMF), Дэлхийн Банк, АХБ зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэж байна.

4. Монгол улс эдийн засгийн шилжилт, эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхэд олон шаардлагатай тулгарч байна. Гэвч шилжилт анхны үр дүнд хүрч, эргэлт буцалтгүй болжээ. Монгол улс эдийн засгийг хөгжүүлэх ихээхэн чадавхитай бөгөөд олон улсын худалдаанд байгалийн баялаг, газарзүйн давуу тал байна. Дараагийн 10 жилд өөрийн хүчин чармайлт, олон улсын хамтын нийгэмлэг, олон улсын байгууллагуудын тусламжаар Монгол өөрийн дотоод эдийн засаг болон эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд сайхан ирээдүй байна гэж хэлж болох байна.